



XII/2021


Тархаасан: 2022 оны 01 дүгээр сарын 14



Үнэмлэхүй бага температур 2021 оны 12 дугаар сард Завхан аймгийн Тосонцэнгэл, Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд -40.3⁰C-д хүрсэн байна

Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 12 дугаар сард Өвөрхангай аймгийн Есөнзүйл суманд +8.4⁰C, үнэмлэхүй бага температур Завхан аймгийн Тосонцэнгэл, Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд -40.3⁰C-д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР (°C), олон жилийн дундажтай¹ харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 12 дугаар сарын байдлаар



¹ - Сүүлийн 30 жил

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2021 оны 12 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр хэмжээ Орхон аймгийн Жаргалант суманд 8.1 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Өмнөговь аймгийн Гурвантэс, Даланзадгад сумдад 24м/с-д хүрсэн байна.

Агаарын чанар


Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын хамгийн их агууламж 2021 оны 12 дугаар сард Богд хааны ордон музей, Мишээл экспо төв, 13-р хороолол, Ургах наран хороолол, Хархорин, Баруун дөрвөн зам, 5-н буудал, 32-ын тойрог, Баянхошуу, Хайлааст, 1-р хороолол, Амгалан, Нисэх, Зурагт орчимд 0.099мг/м³-0.658 мг/м³ -д хүрч, агаарын чанарын хүлцэх агууламжаас 0.049 мг/м³-0.608 мг/м³-ээр буюу 2.0-13.2 дахин их байна.

Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2021 оны 12 дугаар сард Хайлааст, Богд хааны ордон музей, Ургах наран хороолол, Амгалан, 5-н буудал, Нисэх, 13-р хороолол, 1-р хороолол, Баруун дөрвөн зам, Хархорин орчимд 0.063 мг/м³-0.178 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.013 мг/м³ -0.128 мг/м³- ээр буюу 26.0 хувиас-3.6 дахин их байна.

Харин PM 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2021 оны 12 дугаар сард Богд хааны ордон музей, Зурагт, Мишээл экспо төв, Нисэх, Амгалан, 5-н буудал, Толгойт, 32-ын тойрог, Баруун дөрвөн зам, 1-р хороолол, Хархорин, Ургах наран хороолол, Хайлааст, 13-р хороолол, Баянхошуу орчимд 0.198 мг/м³ – 0.598 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.098 мг/м³ – 0.498 мг/м³-ээр буюу 2.0-6.0 дахин их байна.

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 2021 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.069 мг/м³ (32.6%)-ээр буурсан бол азотын давхар ислийн дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.016 мг/м³ (30.0%)-ээр, PM 10 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.032 мг/м³ (23.9%)-ээр, PM 2.5 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.022 мг/м³ (23.9%)-ээр тус тус их байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 12 дугаар сарын байдлаар, мг/м³



Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2021 онд 4053 болж, өмнөх оноос 76 (1.9%) -аар өссөн байна. Газар хөдлөлт 2021 онд 295 удаа бүртгэгдэж, өмнөх оноос 239 (5.3 дахин)-өөр нэмэгдсэн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 онд нийт 319 хүн амь насаа алдаж, өмнөх оноос 76 (31.3%)-гаар нэмэгдсэн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 онд 25.8 тэрбум төгрөгийн хохирол учирч, 0.5 тэрбум төгрөг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	<u>2021</u> <u>2020</u>
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	4 774	5 123	3 977	4 053	101.9
Газар хөдлөлтийн тохиолдлын тоо	35	39	56	295	5.3 ¹
Объектын түймрийн тоо	3 826	4 301	3 036	2 671	88.0
Амь насаа алдсан хүний тоо	206	207	243	319	131.3
Учирсан хохирол, тэрбум төгрөг	81.9	35.8	31.3	25.8	82.4
Зарцуулсан зардал, тэрбум төгрөг	10.4	1.1	0.5	0.5	96.5

¹ - Дахин их

² - Корона вирус халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



Эх үүсвэр:

Цаг уур, орчны шинжилгээний газар
Онцгой байдлын ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь:

2022 оны 02 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212